



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар А/148

Булган сум

**Булган сумын Тохижилт үйлчилгээний ангид
дэмжлэг үзүүлэх тухай**


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган сумын Засаг даргын хүсэлтийн дагуу Булган сумын Тохижилт үйлчилгээний ангид явган хүний зам цэвэрлэгээний олон үйлдэлт тоног төхөөрөмж худалдан авахад шаардлагатай 18,000,000 (арван найман сая) төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай хөрөнгийг Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ТҮРЭВ-ОЧИР



6326010194